

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Улаангом политехник коллежийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2023/54/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Улаангом хот
2023 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,

Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь

Утас: 70453317, Цахим хаяг:
BatsuuriM@audit.gov.mn

Аудитын менежер: М.Бат-Амгалан

Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgаланm@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Авирмэд

Утас: 70453799, Цахим хаяг: AvirmedB@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	13
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	13
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....	14
4. Аудитын тайлан.....	16
4.1 Ерөнхий зүйл	16
4.2 Материаллаг байдал	16
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. Аудитын илрүүлэлт	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

2023.02.10 № 2ВА-2023/54/НА-СТА-ТШЗ
танай _____-ны № _____-т

УЛААНГОМ ПОЛИТЕХНИК
КОЛЛЕЖИЙН ЗАХИРАЛ
Д.БАТТОГТОХ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улаангом политехник коллежийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Улаангом политехник коллежийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд магадлан итгэмжлэлийн гэрчилгээгээ 5 жилийн хугацаагаар сунгуулсан байна.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>463,326,402.37</u>	<u>607,162,682.66</u>
33	АВЛАГА	11,264,089.94	64,707,104.23
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	58,083.96	351,189.25
33300	Татаас, санхүүжилтийн авлага	944,043.00	00.00
335	Бусад авлага	10,261,962.98	64,355,914.98
3351	Байгууллагаас авах авлага	571,993.00	54,665,945.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	9,689,969.98	9,689,969.98
35	БАРАА МАТЕРИАЛ	452,062,312.43	542,455,578.43
351	Түүхий эд материал	274,892,696.60	310,992,672.60
35110	Тусгай зориулалттай материал	274,336,518.60	310,296,494.60
35130	Эм боох материал	556,178.00	696,178.00
354	Хангамжийн материал	157,184,615.83	210,192,905.83
35410	Бичиг хэргийн материал	1,655,200.00	1,394,800.00
35420	Аж ахуйн материал	8,296,215.00	8,592,015.00
35430	Сэлбэг хэрэгсэл	1,751,500.00	9,464,100.00
35450	Барилгын засварын материал	52,330,189.00	58,751,649.00
35460	Хүнсний материал	21,202,586.00	24,713,996.00
35470	Бусад хангамжийн материал	71,948,925.83	107,276,345.83
35600	Мал амьтад	19,985,000.00	21,270,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>4,855,744,172.79</u>	<u>4,785,647,610.02</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,855,744,172.79	4,785,647,610.02
392	Биет хөрөнгө	4,043,849,372.79	3,973,752,810.02
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,875,431,659.00	3,875,431,659.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-333,698,627.24	-394,030,336.04
39203	Авто-тээврийн хэрэгсэл	210,428,925.00	210,428,925.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-75,586,425.00	-90,762,216.74
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,869,531,557.27	1,909,272,607.27
39206	Хуримтлагдсан элэгдэл	-1,637,149,050.02	-1,712,418,283.14
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	284,937,918.50	336,342,658.50
39208	Хуримтлагдсан элэгдэл	-224,120,124.81	-238,837,393.92
39214	Бусад үндсэн хөрөнгө	180,898,115.60	180,898,115.60
39215	Хуримтлагдсан элэгдэл	-177,741,782.51	-178,052,532.51
39217	Ном	70,917,207.00	75,479,607.00
393	Биет бус хөрөнгө	811,894,800.00	811,894,800.00
39301	Программ хангамж	29,857,703.20	29,857,703.20
39302	Хуримтлагдсан элэгдэл	-29,857,703.20	-29,857,703.20
39303	Бусад биет бус хөрөнгө	811,894,800.00	811,894,800.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>5,319,070,575.16</u>	<u>5,392,810,292.68</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>228,900.00</u>	<u>137,500.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	228,900.00	137,500.00
413	Өглөг	228,900.00	137,500.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	4,400.00	00.00
4136	Бусад өглөг	224,500.00	137,500.00

41361	Байгууллагад төлөх өглөг	224,500.00	137,500.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>5,318,841,675.16</u>	<u>5,392,672,792.68</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	5,318,841,675.16	5,392,672,792.68
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	4,315,315,463.70	4,315,315,463.70
51101	Өмч: - төрийн	4,315,315,463.70	4,315,315,463.70
512	Хуримтлагдсан үр дүн	-1,345,875,969.78	-1,272,044,852.26
51210	Өмнөх үеийн үр дүн	-1,345,875,969.78	-6,653,682,455.00
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	5,381,637,602.74
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,349,402,181.24	2,349,402,181.24
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>5,319,070,575.16</u>	<u>5,392,810,292.68</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,181,951,579.20	8,793,320,553.22
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	133,432,979.20	5,437,449,663.22
120	Нийтлэг татварын бус орлого	133,432,979.20	5,437,449,663.22
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	133,432,979.20	5,437,449,663.22
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	24,117,460.00	00.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	19,271,600.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	90,043,919.20	5,437,449,663.22
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,048,518,600.00	3,355,870,890.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,873,393,600.00	2,762,312,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,873,393,600.00	2,762,312,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	175,125,000.00	61,391,890.00
131103	ЗГНХ,ЗДНХ,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөр	35,000,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	135,600,000.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,525,000.00	61,391,890.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	532,166,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	532,166,900.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,116,068,465.69	3,411,682,950.48
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,116,068,465.69	3,411,682,950.48
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,951,994,936.30	3,146,249,884.40
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,925,339,016.00	2,048,578,612.00
210101	Үндсэн цалин	1,115,763,929.95	1,311,935,594.00
210102	Нэмэгдэл	644,979,627.10	551,749,040.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	68,330,230.00	68,899,752.00
210104	Урамшуулал	96,265,228.95	115,994,226.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	246,685,943.16	251,587,624.63
210201	Тэтгэврийн даатгал	174,233,553.11	174,532,966.93
210202	Тэтгэмжийн даатгал	19,038,792.81	20,548,479.80
210203	ҮОМШӨ-ний даатгал	15,227,674.09	16,783,292.60

210204	Ажилгүйдлийн даатгал	3,542,877.49	3,672,833.70
210205	Эрүүл мэндийн даатгал	34,643,045.66	36,050,051.60
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	377,233,147.06	342,382,517.00
210301	Гэрэл, цахилгаан	21,309,572.06	28,697,553.00
210302	Түлш, халаалт	335,029,200.00	280,935,248.00
210303	Цэвэр, бохир ус	20,894,375.00	32,749,716.00
2104	Хангамж, бараа материалын зардал	24,900,878.00	30,021,130.00
210401	Бичиг хэрэг	3,585,510.00	4,406,150.00
210402	Тээвэр, шатахуун	9,982,250.00	14,334,850.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,965,468.00	3,048,650.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,248,100.00	1,709,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,119,550.00	6,521,880.00
2105	Нормативт зардал	51,955,131.00	101,331,372.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,129,300.00	2,129,042.00
210502	Хоол, хүнс	31,311,120.00	76,585,290.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	19,514,711.00	22,617,040.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	41,249,000.00	46,958,220.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	765,000.00
210604	Урсгал засвар	41,249,000.00	46,193,220.00
2107	Томилолт, зочны зардал	00.00	2,443,700.00
210702	Дотоод албан томилолт	00.00	2,443,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,274,049.00	6,933,036.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,269,356.00	2,729,476.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	6,019,440.00	2,336,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	227,025.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	102,000.00	185,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	00.00	66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	511,500.00	978,000.00
210807	Газрын төлбөр	371,753.00	411,535.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	275,357,772.08	316,013,672.77
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	94,926,516.60	150,208,920.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	180,431,255.48	165,804,752.77
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	164,073,529.39	265,433,066.08
2132	Бусад урсгал шилжүүлэг	141,089,138.00	135,250,356.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	11,978,486.00	18,715,400.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	125,812,452.00	111,860,806.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,298,200.00	4,674,150.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	22,984,391.39	119,820,054.75
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	22,984,391.39	119,820,054.75
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	10,362,655.33
213401	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт төсөвт байгууллага	00.00	2,976.88
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	10,359,678.45
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	65,883,113.51	5,381,637,602.74
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	65,883,113.51	5,381,637,602.74

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	3,124,235,397.00	3,357,044,933.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	43,389,060.00	00.00
120	Нийтлэг татварын бус орлого	43,389,060.00	00.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	43,389,060.00	00.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	24,117,460.00	00.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	19,271,600.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,080,846,337.00	3,357,044,933.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,873,393,600.00	2,762,312,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,873,393,600.00	2,762,312,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	175,125,000.00	62,565,933.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	35,000,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	135,600,000.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,525,000.00	62,565,933.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	532,166,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	532,166,900.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	32,327,737.00	00.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	32,327,737.00	00.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	2,955,680,497.00	3,292,395,083.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,955,680,497.00	3,292,395,083.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,760,014,230.61	3,028,953,086.92
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,925,339,016.00	2,048,578,612.00
210101	Үндсэн цалин	1,115,763,929.95	1,311,935,594.00
210102	Нэмэгдэл	644,979,627.10	551,927,261.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	68,330,230.00	68,793,637.00
210104	Урамшуулал	96,265,228.95	115,922,120.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	246,645,442.61	251,790,729.92
210201	Тэтгэврийн даатгал	174,193,052.56	174,759,820.50
210202	Тэтгэмжийн даатгал	19,038,792.81	20,548,479.60
210203	ҮОМШӨ-ний даатгал	15,227,674.09	16,297,663.69
210204	Ажилгүйдлийн даатгал	3,542,877.49	3,649,085.93
210205	Эрүүл мэндийн даатгал	34,643,045.66	36,535,680.20
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	377,302,015.00	396,476,469.00
210301	Гэрэл, цахилгаан	21,378,440.00	28,697,553.00
210302	Түлш, халаалт	335,029,200.00	335,029,200.00
210303	Цэвэр, бохир ус	20,894,375.00	32,749,716.00
2104	Хангамж, бараа материалын зардал	18,478,228.00	19,940,480.00
210401	Бичиг хэрэг	4,332,710.00	3,973,750.00
210402	Тээвэр, шатахуун	4,379,950.00	5,620,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,965,468.00	3,048,650.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,567,300.00	1,293,800.00

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,232,800.00	6,004,280.00
2105	Нормативт зардал	55,741,000.00	111,167,430.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	651,700.00	1,475,050.00
210502	Хоол, хүнс	41,499,300.00	77,139,380.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	13,590,000.00	32,553,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	54,628,875.00	81,506,081.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	500,000.00	2,272,500.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	14,617,000.00
210604	Урсгал засвар	54,128,875.00	64,616,581.00
2107	Томилолт, зочны зардал	00.00	2,443,700.00
210702	Дотоод албан томилолт	00.00	2,443,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,186,049.00	7,140,036.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,269,356.00	2,729,476.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	6,019,440.00	2,336,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	227,025.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	102,000.00	184,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	00.00	66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	423,500.00	1,186,000.00
210807	Газрын төлбөр	371,753.00	411,535.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	72,693,605.00	109,909,549.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	72,693,605.00	109,909,549.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	195,666,266.39	263,441,996.08
2132	Бусад урсгал шилжүүлэг	172,681,875.00	133,259,286.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	32,327,737.00	00.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	11,978,486.00	18,715,400.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	125,812,452.00	111,860,806.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,563,200.00	2,683,080.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	22984391.39	119820054.75
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	22,984,391.39	119,820,054.75
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	10,362,655.33
213401	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт төсөвт байгууллага	00.00	2,976.88
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	10,359,678.45
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>168,554,900.00</u>	<u>64,649,850.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	<u>168,554,900.00</u>	<u>64,649,850.00</u>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	<u>168,554,900.00</u>	<u>64,649,850.00</u>
2200	Дотоод эх үүсвэрээр	<u>168,554,900.00</u>	<u>64,649,850.00</u>
222001	Тоног төхөөрөмж	45,320,000.00	00.00
223001	Бусад хөрөнгө	88,660,000.00	00.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	34,574,900.00	64,649,850.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-168,554,900.00</u>	<u>-64,649,850.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	4,315,315,463.70	2,349,402,181.24	-1,411,759,083.29	5,252,958,561.65
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,315,315,463.70	2,349,402,181.24	-1,411,759,083.29	5,252,958,561.65
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	47,933,132.13	47,933,132.13
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,315,315,463.70	2,349,402,181.24	-1,345,875,969.78	5,318,841,675.16
D01	2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	4,315,315,463.70	2,349,402,181.24	-1,345,875,969.78	5,318,841,675.16
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	-5,307,806,485.22	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,315,315,463.70	2,349,402,181.24	-6,653,682,455.00	11,035,189.94
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	5,381,637,602.74	5,381,637,602.74
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,315,315,463.70	2,349,402,181.24	-1,272,044,852.26	5,392,672,792.68

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,294,479,000.00	3,164,299,266.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,294,479,000.00	3,164,299,266.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,153,248,900.00	3,032,322,980.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,128,963,400.00	2,039,620,055.00
210101	Үндсэн цалин	1,300,776,900.00	1,305,381,244.00
210102	Нэмэгдэл	662,395,100.00	549,523,054.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	68,607,000.00	68,793,637.00
210104	Урамшуулал	97,184,400.00	115,922,120.00

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	266,120,100.00	250,691,656.80
210201	Тэтгэврийн даатгал	186,633,300.00	173,998,343.17
210202	Тэтгэмжийн даатгал	19,871,600.00	20,458,894.03
210203	ҮОМШӨ-ний даатгал	15,897,300.00	16,225,995.23
210204	Ажилгүйдлийн даатгал	3,974,300.00	3,633,421.41
210205	Эрүүл мэндийн даатгал	39,743,600.00	36,375,002.96
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	405,544,100.00	396,476,469.00
210301	Гэрэл, цахилгаан	37,900,000.00	28,697,553.00
210302	Түлш, халаалт	335,044,100.00	335,029,200.00
210303	Цэвэр, бохир ус	32,600,000.00	32,749,716.00
2104	Хангамж, бараа материалын зардал	24,392,000.00	24,025,680.00
210401	Бичиг хэрэг	3,687,100.00	3,775,750.00
210402	Тээвэр, шатахуун	4,201,000.00	5,470,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,776,300.00	3,048,650.00
210404	Ном, хэвлэл	4,870,400.00	4,562,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,053,300.00	1,293,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,803,900.00	5,875,080.00
2105	Нормативт зардал	113,518,400.00	111,167,430.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,865,100.00	1,475,050.00
210502	Хоол, хүнс	78,055,900.00	77,139,380.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	32,597,400.00	32,553,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	95,469,600.00	94,331,581.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	15,300,000.00	15,098,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	14,635,400.00	14,617,000.00
210604	Урсгал засвар	65,534,200.00	64,616,581.00
2107	Томилолт, зочны зардал	5,590,100.00	2,443,700.00
210702	Дотоод албан томилолт	5,590,100.00	2,443,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,495,300.00	4,410,560.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,336,000.00	2,336,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	240,000.00	227,025.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	184,000.00	184,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	132,000.00	66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,190,400.00	1,186,000.00
210807	Газрын төлбөр	412,900.00	411,535.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	109,155,900.00	109,155,849.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	109,155,900.00	109,155,849.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	141,230,100.00	131,976,286.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	141,230,100.00	131,976,286.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	18,715,400.00	18,715,400.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	121,107,800.00	111,860,806.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,406,900.00	1,400,080.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,294,479,000.00	3,164,299,266.80
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,294,479,000.00	3,164,299,266.80
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,762,312,100.00	2,642,492,045.25

131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	532,166,900.00	521,807,221.55
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	122.00	123.00
620001	Удирдах ажилтан	03.00	03.00
620002	Гүйцэтгэх ажилтан	89.00	89.00
620003	Үйлчлэх ажилтан	30.00	31.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	62,562,956.12
21	УРСГАЛ ЗАРДАЛ	62,562,956.12
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	61,279,956.12
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	8,958,557.00
210101	Үндсэн цалин	6,554,350.00
210102	Нэмэгдэл	2,404,207.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,099,073.12
210201	Тэтгэврийн даатгал	761,477.33
210202	Тэтгэмжийн даатгал	89,585.57
210203	ҮОМШӨ-ний даатгал	71,668.46
210204	Ажилгүйдлийн даатгал	15,664.52
210205	Эрүүл мэндийн даатгал	160,677.24
2104	Хангамж, бараа материалын зардал	477,200.00
210401	Бичиг хэрэг	198,000.00
210402	Тээвэр, шатахуун	150,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	129,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	42,771,950.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,941,950.00
210602	Тавилга	31,830,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,729,476.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,729,476.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5243700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,243,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1283000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,283,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,283,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	62,562,956.12
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	62,562,956.12
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	62,562,956.12
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

3 . САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Улаангом политехник коллеж нь мэргэжлийн боловсролын сургалтын үйл ажиллагаа явуулдаг байгууллага юм. Улаангом политехник коллеж нь хүнлэг, оюунлаг, баялаг үйлдвэрлэгчдийг бэлтгэнэ гэсэн зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ✓ Хөдөлмөрийн тухай хууль - Шинэчлэн найруулгыг 2022 оны 01 сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн.
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хууль -2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр батлагдсан.
- ✓ Төрийн албаны тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 05-ны өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр нэмэлт өөрчлөлтүүд оруулсан байна.
- ✓ Төсвийн тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ний өдөр, 7 дугаар сарын 01-ний өдөр, 8 дугаар сарын 29-ний өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчаас эрсдэлд суурилсан дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Улаангом политехник коллежийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Улаангом политехник коллежийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Улаангом политехник коллежийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 73,739.7 мянган төгрөгөөр буюу 1.4 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	11,264.1	64,707.1	53,443.0
Урьдчилгаа			
Бараа материал	452,062.3	542,455.6	90,393.3
Үндсэн хөрөнгө	4,855,744.2	4,785,647.6	-70,096.6
Нийт хөрөнгө	5,319,070.6	5,392,810.3	73,739.7
Өр төлбөр	228.9	137.5	-91.4
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	5,318,841.7	5,392,672.8	73,831.1
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	5,319,070.6	5,392,810.3	73,739.7

Авлага 53,443.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь НДШ, түлш халаалтын авлага үүссэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 542,455.6 мянган төгрөг болж 90,393.3 мянган төгрөгөөр өссөн нь багш нарын хийсэн бүтээгдэхүүн, БНСУ-ын WITH төрийн бус байгууллагаас үнэ төлбөргүй бараа материал ирснээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 4,785,647.6 мянган төгрөг болж 70,096.6 мянган төгрөгөөр буурсан нь хуримтлагдсан элэгдлийн зардлаас шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл өмнөх оноос 73,831.1 мянган төгрөгөөр буюу 1.4 хувиар өссөн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 3,555,264.9 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 3,555,264.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 653,448.7 мянган төгрөгөөр бууруулж 2,901,816.2 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь хангамж бараа материалын зардал, хоол хүнс, тавилга эд хогшил, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээ, шагнал, урамшууллын зардлуудын санхүүжилт буурч ирсэнтэй холбоотой байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 3,294,479.0 мянган төгрөгийн төсөв баталснаас 2,762,312.1 мянган төгрөгийг улсын төсвөөс, 532,166.9 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс тус тус санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,642,492.0 мянга, орон нутгийн төсвөөс 521,807.2 мянга, нийт 3,164,299.2 мянган төгрөгийг урсгал үйл ажиллагаанд зарцуулж, 130,179.7 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,164,299.2 мянган төгрөг буюу 96.1 хувьтай байгаа нь 130,179.7 мянган төгрөгийг хэмнэж төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Мэргэжлийн боловсрол, Үндсэн үйл ажиллагааны зардал	2,543,026.1	2,433,376.4	109,649.7	95.6%
2	Мэргэжлийн боловсрол, Ажил олгогчоос олгох тэтгэмж	141,230.1	131,976.3	9,253.8	93.4%
3	Мэргэжлийн боловсрол, Дотуур байрны үйлчилгээ	78,055.9	77,139.4	916.5	98.8%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 62,565.9 мянга төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Гүйцэтгэлээр 62,562.9 мянга төгрөгийг урсгал үйл ажиллагаанд зарцуулж, 3.0 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Улаангом политехник коллежийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Авирмэд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Улаангом политехник коллежийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 1/07 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцож 24.9 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Гүйцэтгэлийн үе шатанд 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 3,411.7 сая төгрөгийн 1.0 хувь буюу 34.1 сая төгрөгөөс 80 хувиар тооцож 27.3 сая төгрөгөөр тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Улаангом политехник коллежийн тухайн хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлсэн. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Улаангом политехник коллежийн захирал Д.Баттогтох нь 2017 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн сайдын тушаалаар чөлөөлөгдөж Нийслэлийн захиргааны хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэрээр ажлаас үндэслэлгүй халагдсан гэж үзэн ажилд нь эргүүлэн томилж ажиллаагүй хугацааны цалинг олгож нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг нөхөн бичих шийдвэр гаргасан байна.

Шүүхийн шийдвэрийн дагуу Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 8 дугаар сарын 26-ны өдрийн Б/21 тоот тушаалаар ажилд эргүүлэн томилсон байна. 2022 онд ажиллаагүй хугацааны цалинд 12,504.5 мянган төгрөг авсныг буруу шийдвэр гаргасан албан тушаалтнаар нөхөн төлүүлж төрийг хохиролгүй болгуулах асуудлыг Үндэсний аудитын газрын нэгтгэл тайланд тусгуулах албан бичиг хүргүүлэхээр тогтов.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 146, хугацаа хоцроож байршуулсан 3, хугацаа болоогүй хүлээгдэж байгаа 2 мэдээлэл байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Улаангом политехник коллежийн 2022 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,000.0 мянган төгрөгийн 1 зөрчил илэрсэнд төлбөрийн акт тогтоолоо.

5.1 Төлбөрийн акт

Улаангом политехник коллеж нь хөрс боловсруулах лидер-4 төхөөрөмж түрээслүүлсний орлого 1.000.0 мянган төгрөгийг байгууллагын дансанд төвлөрүүлээгүй төрд хохирол учруулсан зөрчилд төлбөрийн акт тогтоов.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Хөрс боловсруулах лидер-4 төхөөрөмж түрээслүүлсний орлого 1000000 төгрөгийг төсөвт төвлөрүүлээгүй	1	1,000.0	1	1,000.0								
Дүн	1	1,000.0	1	1,000.0								

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  /М.БАТСУУРЫ/

АУДИТЫН МЕНЕЖЕР

/М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР

/Б.АВИРМЭД/

2023 оны 02 сарын 10-ны өдөр